



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨААТҮГ-ЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/05/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Энхжин
Утас: 261628 Цахим хаяг: enkhjinb@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Баян ташаагийн эх аудит
ХХК-ийн захирал Т.Хоролсүрэн
Утас: 99116028 Цахим хаяг: bte.audit@yahoo.com

Улаанбаатар хот
2023 он

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа	9
3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	10
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар	14
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Төлбөрийн акт	14
5.2 Албан шаардлага	14
5.3 Зөвлөмж	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	17
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	17
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН
ТӨВ ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ц.АМАРСАНАА ТАНАА

2023 03.21 № 07/632
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2022 оны орлогын төлөвлөгөөгөөр 2,415.4 сая төгрөг төвлөрүүлэхээс 4,810.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 310 дугаар тогтоолоор Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг тодотгон үйл ажиллагааны орлогыг 9,996.4 сая, зардлыг 9,461.0 сая, 481.9 сая төгрөг татварын дараах ашигтай байхаар баталжээ. Гүйцэтгэлээр 9,383.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, зардал 8,702.9 сая төгрөгт хүрч, 903.1 сая төгрөгийн татварын дараах ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 34 зорилтын хүрээнд 70 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.Наранчимэг

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	19,140,918,389.26	22,267,836,164.47
1.1.2	Дансны авлага	20,129,541.23	23,013,913.87
1.1.3	Татвар, НД-н шимтгэлийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	327,501,795.52	385,720,147.54
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/ тооцоо		154,831,510.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	19,488,549,726.01	22,831,401,735.88
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,857,125,307.67	5,840,106,814.34
1.2.2	Биет бус хөрөнгө	1,383,237,776.28	1,193,923,141.64
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.9	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	7,240,363,083.95	7,034,029,955.98
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	26,728,912,809.96	29,865,431,691.86
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	3,172,278,393.38	3,167,197,253.41
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өглөг	152,135,248.50	36,746,457.44
2.1.1.4	НДШ-ийн өглөг	49,838.37	
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	8,098,487,082.16	11,073,508,662.94
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	756,185,469.42	800,311,838.96
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	12,179,136,031.83	15,077,764,212.75
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
	Өр төлбөрийн нийт дүн	12,179,136,031.83	15,077,764,212.75
2.2	Эзэмшигчдийн өмч		
2.2.1	Өмч: а) төрийн	8,159,338.00	8,159,338.00
2.2.2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,337,339,884.99	1,337,339,884.99
2.2.3	Нэмж төлөгдсөн капитал	195,479,515.00	195,479,515.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	6,454,791,998.45	6,454,791,998.45
2.4	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	6,554,006,041.69	6,791,896,742.67
	Эзэмшигчдийн өмчийн дүн	14,549,776,778.13	14,787,667,479.11
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	26,728,912,809.96	29,865,431,691.86

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	8,496,391,809.31	9,372,303,198.09
2	Борлуулалтын өртөг	113,924,476.87	84,424,146.79
3	Нийт ашиг (алдагдал)	8,382,467,332.44	9,287,879,051.30
5	Хүүгийн орлого	132,553,923.67	11,451,502.31
6	Бусад орлого		
7	Ерөнхий ба удирдлагын зардал	6,600,644,348.00	8,618,444,914.30
8	Санхүүгийн зардал		
9	Бусад зардал		120,000.00
10	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-17,750,924.83	38,823,289.07
11	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-55,384,470.12	250,473,186.30
12	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,841,241,513.16	970,062,114.68
13	Орлогын татварын зардал / (буцаалт)	178,182,298.44	66,931,413.70
14	Татварын дараах ашиг (алдагдал)	1,663,059,214.72	903,130,700.98
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,663,059,214.72	903,130,700.98
16	Бусад дэлгэрэнгүй орлого		
17	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
18	Орлогын нийт дүн	1,663,059,214.72	903,130,700.98
19	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	1,067,439,884.99	6,454,791,998.45	4,948,286,048.58	12,674,156,785.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					(57,339,221.61)	(57,339,221.61)
Залруулсан үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	1,067,439,884.99	6,454,791,998.45	4,890,946,826.97	12,616,817,563.41
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					1,663,059,214.72	1,663,059,214.72
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	1,337,339,884.99	6,454,791,998.45	6,554,006,041.69	14,549,776,778.13
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө,					(665,240,000.00)	(665,240,000.00)

**Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан**

алдааны залруулга						
Залруулсан үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	1,337,339,884.99	6,454,791,998.45	5,888,766,041.69	13,884,536,778.13
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					903,130,700.98	903,130,700.98
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	1,337,339,884.99	6,454,791,998.45	6,791,896,742.67	14,787,667,479.11

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	19,347,583,578.64	22,490,878,728.95
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	19,292,506,868.64	22,485,138,924.95
1.1.2	Буцаан авсан албан татвар		
1.1.3	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.4	Бусад мөнгөн орлого	55,076,710.00	5,739,804.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	14,010,511,295.32	18,947,442,395.12
1.2.1	Ажиллагчдад төлсөн	3,172,035,319.83	3,978,215,904.64
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,648,183,521.24	2,038,569,227.88
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	6,305,574,024.76	7,126,364,384.14
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	56,949,068.26	23,336,525.63
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хэрэгсэл, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,529,494,549.31	3,673,177,832.13
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	782,895,271.27	1,103,013,951.27
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	515,379,540.65	1,004,764,569.43
	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,337,072,283.32	3,543,436,333.83
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	132,553,923.67	11,451,502.31
2.1.2	Хүлээн авсан хүүгийн орлого	132,553,923.67	11,451,502.31
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	432,626,753.50	466,793,350.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	432,626,753.50	466,793,350.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	300,072,829.83	455,341,847.69
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,298,083.12	43,817,054.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	2,298,083.12	43,817,054.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	20,049,007.95	4,993,764.93
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

3.2.3	Валютын ханшийн зөрүү	20,049,007.95	4,993,764.93
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	17,750,924.83	38,823,289.07
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	5,019,248,528.66	3,126,917,775.21
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,121,669,860.60	19,140,918,389.26
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,140,918,389.26	22,267,836,164.47

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	2021 оны гүйцэтгэл	2022 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, түгээлт борлуулалт					
2	Захиалагч хяналтын орлого	4,567,877.9	4,577,000.0	5,611,490.9	1,034,491.0	122.6
3	Нормчлолтой холбоотой орлого	424,807.1	507,402.5	415,000.9	(92,402.0)	81.8
4	Инженер техникийн ажилтны сургалтын орлого	394,736.5	454,640.0	329,802.5	(124,838.0)	72.5
5	Бүтээгдэхүүн баталгаажуулалтын орлого	40,519.6	117,570.0	59,833.3	(57,737.0)	50.9
6	Зураг төсөл, магадлалын орлого	1,699,938.1	1,850,000.0	2,275,741.8	425,742.0	123.0
7	Лабораторийн орлого	246,290.1	534,800.0	490,956.6	(43,843.0)	91.8
8	Бусад орлого /БАЖ, ХАБЭАхуйн өдөр тутмын зааварчилгааны дэвтэр, хүүгийн орлого/	1,254,776.4	1,955,005.8	200,928.7	(1,754,077.0)	10.3
2	Нийт орлого	8,628,945.7	9,996,418.3	9,383,754.7	(612,664.0)	93.9
	Үүнээс: Цэвэр борлуулалт	8,515,021.2	9,876,418.3	9,299,330.6	(577,088.0)	94.2
3	Нийт зардал	6,714,568.8	9,461,003.0	8,702,869.0	(758,134.0)	92.0
	Үүнээс: Удирдлагын зардал	364,464.1	319,452.4	348,733.8	29,281.0	109.2
4	Үйл ажиллагааны бус зардал		-	120.0	120.0	
5	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(17,750.9)		38,823.3	38,823.0	
6	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(55,384.5)		250,473.2	250,473.0	
7	Татварын өмнөх ашиг	1,841,241.5	535,415.3	970,062.2	434,647.0	181.2
8	Цэвэр ашиг/алдагдал/	1,663,059.2	481,873.8	903,130.8	421,257.0	187.4
9	Төсвийн төлбөрт нийт дүн	2,518,411.9	2,106,012.0	3,165,467.0	1,059,455.0	150.3
	а/ Орлогын татварт	137,290.9	48,187.4	186,710.8	138,523.0	387.5
	б/НДШ	1,655,335.3	1,448,689.8	2,040,314.5	591,625.0	140.8
	в/Хүн хүний орлогын албан татвар	646,325.1	562,414.9	855,959.5	293,545.0	152.2
	г/ Улсын тэмдэгтийн хураамж	-	-	-	-	
	д/ Бусад татварт / газрын төлбөр, даатгал, ХХ-ээс суутгасан ХОАТ, тээврийн хэрэгслийн татварт, ҮХХАТ/	79,460.6	46,720.0	82,482.3	35,762.0	176.5
10	Төрийн өмчийн ногдол ашигт	665,240.0	240,936.9	451,565.4	210,628.0	187.4
11	Нийт ажиллагсдын тоо	170.0	187.0	170.0	(17.0)	90.9
12	Нийт цалингийн сан	3,952,527.0	5,761,691.1	4,954,569.2	(807,122.0)	88.0
13	Нэг ажиллагчийн дундаж цалин	1,937.5	2,567.6	2,428.7	(139.0)	94.6
14	Борлуулалтын 1 өртөгт ногдох зардал	0.8	1.0	0.9	-	97.9
15	Хөрөнгө оруулалт / өөрийн хөрөнгөөр	552,452.5	597,415.0	373,317.7	(224,097.0)	62.5

16	Нийт авлага	20,129.5	35,000.0	23,013.9	(11,986.0)	65.8
	Нийт өр төлбөр	12,179,136.0	8,650,000.0	15,077,764.2	6,527,764.0	176.3
	Үүнээс: 1. Нормчлолын сангийн бүрдүүлэлтэй холбоотой БХБЯ-нд өгөх өглөг	5,029,401.2	3,500,000.0	8,135,313.9	4,635,314.0	232.4
17	2. Экспертизийн ажлын хөлсний өглөг	755,676.7	750,000.0	799,009.4	49,009.0	106.5
	3. УТХО-той барилгуудын зохиогчид өгөх өглөг болон орон нутгийн ГХБХБГ-т өгөх өглөг	3,079,224.8	2,500,000.0	3,085,649.5	585,650.0	123.4

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын зорилго нь нийтийн аж ахуйн талаар төрөөс явуулж буй бодлогын хэрэгжилтийг хангах, барилгын салбарын хөгжлийг түргэтгэгч, дэмжин туслагч түншлэгч байгууллага байх, Барилга, хот байгуулалтын яам болон эрх бүхий бусад байгууллагуудыг шаардлагатай судалгаа, мэдээллээр хангахад оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Салбарын хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;
- Барилгын норм норматив, дүрэм, барилгын төсвийн жишиг үнэлгээ, үнийн индекс, стандарт боловсруулах ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх;
- Барилгын норм нормативын дүрмийг боловсруулах ажлыг зохион байгуулах;
- Барилгын зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах;
- Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах;
- Сургалт зохион байгуулах;
- Барилга, нийтийн аж ахуйн мэдээллийн сан бүрдүүлэн сүлжээ байгуулж, түүний байнгын ажиллагааг хариуцах;
- Салбарын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангуулах;
- Улсын төсөв болон бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд техникийн хяналт гүйцэтгэх;
- Барилгын материал, хийц бүтээцийн дээжид сорилт шинжилгээ хийх, дүгнэлт гаргах гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ыг Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 47 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ үйл ажиллагаандаа Барилгын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”,
- Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол “Автомашин ашиглалтын тухай”.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар судалж, танилцсан болно.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,136.5 сая төгрөгөөр буюу 11.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	19,140,918.4	22,267,836.2	3,126,917.8
Авлага	20,129.5	23,013.9	2,884.4
Бараа материал	327,501.8	385,720.1	58,218.4
Урьдчилж төлсөн зардал тооцоо	-	154,831.5	154,831.5
Үндсэн хөрөнгө	7,240,363.1	7,034,030.0	(206,333.1)
Нийт хөрөнгө	26,728,912.8	29,865,431.7	3,136,518.9
Өр төлбөр	12,179,136.0	15,077,764.2	2,898,628.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	14,549,776.8	14,787,667.5	237,890.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	26,728,912.8	29,865,431.7	3,136,518.9

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,126.9 сая төгрөгөөр өссөн нь 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн УИХ-ийн 88 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангахаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртөгт магадлал хийсэн, гадаадын зээл тусламж болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээнд захиалагчийн техник хяналт хэрэгжүүлсэн орлогоос шалтгаалсан байна.

Авлага дансны эхний үлдэгдлээс хангамжийн материал, шатахуун, түрээсийн урьдчилж төлсөн 18.9 сая төгрөгийн авлага барагдаж, тайлант онд хангамжийн материал, шатахуун, томилолт, сэлбэг хэрэгсэл, ашиглалтын зардал, зөвлөх үйлчилгээний авлага 4,958.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Өмнөх оны үлдэгдлээс барагдаагүй 1.2 сая төгрөгийн сургалттай холбоотой авлагын үлдэгдэлтэй байна.

Бараа материал төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,167.5 сая, төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 1,109.3 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 385.7 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 18 хувиар өссөн байна.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэлд Барилгын салбарын нэгдсэн мэдээллийн сангийн цахим программын хөгжүүлэлт” ажлыг гүйцэтгэх гэрээний 58.9 сая төгрөгийн, ERP хөгжүүлэлт хүний нөөц, санхүүгийн гэрээний удирдлагын программын ажлын 70.4 сая төгрөгийн, барилгын материалын сорилт шинжилгээний материалд шаардлагатай багаж хэрэгслийн нийлүүлэх гэрээний 5.9 сая төгрөгийн, вэб хуудсыг архивлаж мэдээллийг ил тод нээлттэй болгох хөгжүүлэлтийн ажлын 13.7 сая төгрөгийн, серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх гэрээний 5.9 сая төгрөгийн эхний санхүүжилтийг олгосон урьдчилгаа бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгө ТӨБЗГ-ын 2022 оны 310 дугаар тогтоолын дагуу худалдаж авсан 466.8 сая, Жайка Монгол дахь төлөөлөгчийн газраас балансаас балансад шилжүүлсэн 250.5 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2022 оны А-1/2458 дугаар албан бичгийн дагуу Барилга, хот байгуулалтын яаманд балансаас балансад шилжүүлсэн 58.0 сая, тайлант оны байгуулсан элэгдэл 865.6 сая төгрөгөөр тус тус хасагджээ.

Өр төлбөр 2,898.6 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй нийт 588 төсөл арга хэмжээнд зохиогчийн техник хяналт хэрэгжүүлэх зураг, төсвийн зохиогчид өгөх өглөгөөс шалтгаалсан байна. Өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээнд зохиогчийн хяналтын зардлын өглөг 2,342.7 сая, аймгуудын ГХБХБГ-т техник хяналтын зардалд өгөх 742.9 сая, орон тооны бус экспертүүдэд өгөх 799.0 сая, татварын өглөг 36.7 сая, урьдчилж орсон орлого 11,073.5 сая, байгууллагад өгөх өглөг 82.9 сая төгрөгийн өглөг байна.

Барилга байгууламжийн норм, нормативын сангийн үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөөнд 4,958.5 сая төгрөг зарцуулахаас 1,756.4 сая төгрөг зарцуулсан байна. Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд нормчлолын сангийн БХБЯ-нд өгөх өглөг 3,500.0 сая төгрөг төлөвлөснөөс 8,135.3 сая төгрөгийн өглөг үүссэн. Барилга, байгууламжийн норм, нормативын сангийн орлого 4,810.2 сая төгрөг буюу 199 хувиар биелсэн нь өглөг өсөх шалтгаан болжээ.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 14,877.7 сая төгрөг болж 237.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны ашигтай холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал нь байгууллагын

Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 631 дугаар тогтоолоор Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтыг баталсныг 2022 оны 310 дугаар тогтоолоор тодотгосон байна. Тайлант онд нийт орлогыг 9,996.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 9,461.0 сая төгрөгөөр, татварын өмнөх ашгийг 535.4 сая төгрөг байхаар баталжээ. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 597.4 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Нийт орлогын гүйцэтгэл 9,383.8 сая төгрөг болж төлөвлөснөөс 612.6 сая төгрөг буюу 6.1 хувиар тасарсан нь барилгын зарим нэр төрлийн материалын түүхий эдийн үнийн өсөлт, Эрээн Замын-Үүд хоорондох тээврийн үнийн өсөлт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн түүхий эд тасалдах, хил удаан хугацаагаар хаагдаж байгаа зэрэг шалтгаануудаас гол нэр төрлийн өөр орноос оруулж ирдэг материалуудад шинжилгээ хийлгэх нь багассантай холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 8,702.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 758.1 сая төгрөг буюу гүйцэтгэл 92.0 хувьтай байгаа нь орлого дутуу бүрдсэнээс шалтгаалжээ.

Хөрөнгө оруулалтын зардалд 22 төсөл арга хэмжээнд 373.3 сая төгрөг зарцуулсан байна.

Тайлант онд цэвэр ашиг 903.1 сая төгрөг болсон нь зарим зардыг хэмнэж ажилласан нь нөлөөлжээ.

ТӨБЗГ-т тайлант онд 665.2 сая төгрөгийн ногдол ашгийг төвлөрүүлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх ТӨААТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн ТӨААТҮГ-ын үйл ажиллагааг сайжруулах холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян ташаагийн эх аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Хандсүрэн, аудитор С. Бямбанайдан аудиторын туслах Д.Балжирдорж нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Ч.Чимгээ, захирал Т.Хоролсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ 2022 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 1/364 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дүнд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 6,948.1 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцож, 104.2 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь 3 дэд даргыг хуулийн хугацаанд ажлаас нь чөлөөлж ТӨБЗГ-ын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 609 дүгээр тушаалаар баталсан шинэчилсэн бүтэц орон тоог үндэслэн 2022 оны 7 дугаар сарын 01-нээс эхлэн 2 дэд даргыг хот байгуулалт, зураг төслийн институтийн эрхлэгч, ерөнхий инженер орон тоонуудад авч ажиллуулсан байна.

Энэ хуулийн хүрээнд дэд дарга, орлогчийн орон тоог хассанаар 78.1 сая төгрөгийн цалинтай холбоотой зардал, албан тушаалын автомашинтай холбоотой 8.0 сая төгрөгийн цалингийн зардал, сэлбэг, шатахууны зардал 13.3 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд мэдээлэх ёстой орлогын 14,126.9 сая төгрөг, зарлагын 6,347.8 сая төгрөгийн мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан, Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2.1 6.2.1. “эрх бүхий байгууллагаас баталсан жилийн төсөв, гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт”; 6.2.2. орлого “үндсэн үйл ажиллагааны орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого”; 6.2.3. “урсгал зардал /цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, бусад урсгал зардал, хөрөнгийн зардал, татаас шилжүүлэг”; 6.2.6. “зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр /улсын төсөв, орон нутгийн төсөв, өөрийн орлого”. 6.3.3. “төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар”; гэсэн заалттай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулж байх зөвлөмж өгөв

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлтэй холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 10.5 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс жилийн эцэст дахин хянахад зөрчлийг арилгасан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн 13,792.5 сая төгрөгийн 2 зөвлөмж, хүргүүлсэн 36.5 сая төгрөгийн 3 албан шаардлагын биелэлтийг үнэлэхэд хэрэгжилт 99.9 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Б	1	2	3	4	5	6
1	Акт					
2	Албан шаардлага	3	36,546.5	3	36,546.5	99.9
3	Зөвлөмж	2	13,755,922.3	2	13,755,922.3	100.0
	Нийт дүн	5	13,792,468.8	5	13,792,468.8	99.9

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

БХБЯ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Хүн ам нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн үр дүнг аудитад дараагийн аудитаар анхаарах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 97.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 21.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 62.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 13.0 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Сийз архитекс ХХК-ийн 2019, 2020 онуудад хийж гүйцэтгэсэн зохиогчийн хяналтын ажлын 21.3 сая төгрөгийн гэрээний биелэлтийг дүгнээгүй, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй өглөг бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8-д “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”; 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”; гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагатай хийсэн гэрээг дүгнэж, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. Төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага

Тайлант онд 970.8 сая төгрөгийн худалдан авалт зохион байгуулснаас 62.8 сая төгрөгийн худалдан авалтын гэрээг дүгнэж, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8. “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх”; Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10. “гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг”; заалтыг зөрчсөн санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллага аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг дүгнэж, өглөг, авлагын үлдэгдлийг харилцагч тус бүртэй тооцоо нийлж, баталгаажуулж байх, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Авлагын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Байгууллагаас авах 2.0 сая төгрөгийн авлага, өгөх 11,0 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8-д “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”; 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Авлага, өглөгийн үлдэгдлийг харилцагч тус бүртэй тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж байх

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 63.1 сая төгрөгийн хөрөнгийн цаашид ашиглах хугацааг, шинэчлэн тогтоох үнийн саналыг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлээгүй байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 06 сарын 18-ний өдөр, дугаар 271 тогтоолын 6.2.1-д “Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон”, 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийн цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг боловсруулж, ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Үүнээс												/мянган төгрөгөөр/	
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй, 63,068.0 мянган төгрөгийн хөрөнгийг цаашид ашиглах хугацааг шинэчлэн тогтоох, үнийн саналыг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлээгүй.	1	-					1	-						
2	Байгууллагаас авах 1,961.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	1,961.2					1	1,961.2						
3	Тайлант оны эцэст 11,034.9 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	11,035.0					1	11,035.0						
4	Сийз архитекс ХХК-ийн 2019, 2020 онуудад хийж гүйцэтгэсэн зохиогчийн хяналтын ажлын 21.3 сая төгрөгийн гэрээний биелэлтийг	1	21,349.7	1	21,349.7										

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

	Дүгнээгүй, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй өглөг бүртгэлтэй байна.																			
5	Тайлант онд 970,832.2 мянган төгрөгийн худалдан авалт зохион байгуулснаас 62,822.1 мянган төгрөгийн худалдан авалтын гэрээг дүгнэж, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	62,822.1					1	62,822.1	3	12,996.2									
	Дүн	5	97,168.0	1	21,349.7	1	62,822.1	3	12,996.2											

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс																	
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж															
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн														
1	Шилэн дансны цахим системд мэдээлэх ёстой орлогын 14,126,882.3 мянган төгрөг, зарлагын 6,347,753.2 мянган т төгрөгийн мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан, Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1						1													
	Дүн	1	-																		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 03 дугаар сарын 21 № 127/А0150055 Улаанбаатар хот
СНАГ-2023/05/ХА-СТН-ТӨААТҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зохиогч Сийз архитекс ХХК-ийн 2019, 2020 онуудад хийж гүйцэтгэсэн зохиогчийн хяналтын ажлын 21,349,678.00 /Хорин нэгэн сая гурван зуун дөчин есөн мянга зургаан зуун далан найм/ төгрөгийн гэрээг дүгнэж, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; 20.2.6 эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Байгууллагатай хийсэн гэрээг дүгнэж, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 21,349,678.00 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2023 оны 9 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал /Ц.Амарсанаа, Санхүү, төсөл, хөтөлбөрийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Г.Гантуул / нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ХОРОЛСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр.
Утас 51-264230

2-Алс-2023-0115-СНАГ-26-Оакт

0001090087



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 21 № 454/20150055 Улаанбаатар хот
СМАГ-2023/05/НА-СТА-ТӨААТҮГ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 970,832.0 /есөн зуун далан сая найман зуун гучин хоёр/ мянган төгрөгийн худалдан авалт зохион байгуулснаас 62,822,130.00 /жаран найман сая найман зуун хорин хоёр мянга нэг зуун гуч/ төгрөгийн худалдан авалтын гэрээг дүгнэж, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйл 71.8. ер, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйл 49.2.10. "гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагатай хийсэн худалдан авалтын гэрээг дүгнэж үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал /Ц.Амарсанаа, Санхүү, төсөл, хөтөлбөрийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Г.Гантуул / нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ХОРОЛСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban.Shaardlaga\2023\0315\SNAG-40.Docs

0001081004

Утас: +976 51 261585

Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс